



## МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Метро бизнес төв, А блок 5 давхар  
Д.Сүхбаатарын гудамж-13  
Сүхбаатар дүүрэг, УБ 14201-0033  
Утас: 30 42 58, Факс: (976-11) 32 77 20  
Цахим хуудас: www.crc.gov.mn  
Цахим шуудан: info@crc.gov.mn

2021.09.09 № 01/1583

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Зөвлөмжийн биелэлт хүргүүлэх тухай

Харилцаа Холбооны Зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад Үндэсний аудитын газар, Ингүүмэл жаргалант аудит ХХК санхүүгийн тайлангийн аудит хийж менежментийн захидлаар нийт таван зөвлөмж, нэг албан шаардлагыг хүргүүлсэн.

Тус зөвлөмжийн хүрээнд Харилцаа Холбооны Зохицуулах хороо нь 2021 оны 9 дүгээр сарын 07-ны байдлаар дараах арга хэмжээг авч ажиллаж байна.

Үүнд:

#### **Зөвлөмж 1 ажлын хүрээнд:**

Утга: Програм хангамжийн ашиглалтын төлбөрийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн,

2020 онд худалдан авсан байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд ашиглагддаг, систем нь жил бүр шинэчлэгдэн 1 хүртэлх жилийн хугацаатай програм хангамжуудыг Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль, ТӨБЗГ-ын холбогдох журам, 2020 оны эд хөрөнгийн тооллогын үр дүн, Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн “Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасч, актлах тухай” 08 тоот тогтоол, холбогдох хууль, журмын дагуу актлах хүсэлт гарган 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 01/504 тоот албан бичгээр ТӨБЗГазарт хүргүүлсэн бөгөөд тус газраас 2021 он 6 дугаар сарын 16-ны өдрийн А-1/998 тоот “Зөвшөөрөл олгох тухай” хариу албан бичиг холбогдох хууль журмын дагуу үндсэн хөрөнгөөс хасч 2021 оны хагас жилийн тайланд тусган ажиллалаа.

2021 оны батлагдсан төсөв, үйл ажиллагааны хүрээнд худалдан авсан 1 хүртэлх жилийн хугацаанд ашиглагдах нийт 34,2 сая төгрөгийн өртөг бүхий програмуудыг биет бус хөрөнгийн шинж чанар агуулаагүй, ашиглалтын төлбөр гэж үзэн Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн өгсөн зөвлөмжийн дагуу тайлант хугацааны зардлаар бүртгэн ажиллалаа. Програм хангамжтай холбоотой өөрчлөлтүүдийг НББОУС-38, бусад холбогдох стандарт, журамд заасны дагуу байгууллагын НБББББ-т тусган нийцүүлэх ажлыг хийж байна.

*Холбогдох баримтыг хавсаргаав.*

#### **Зөвлөмж 2 ажлын хүрээнд:**

Утга: Тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг хэрхэн хүлээн зөвшөөрөх нь тодорхойгүй, авлагын тооцоо нийлэхэд зөрүү үүсдэг байна,